

Ц.Пүрэв

Социологийн ухааны доктор /Ph.D/

ТООН БА ЧАНАРЛАГ АРГА ЗҮЙН ОНЦЛОГ ТАЛУУД ТООН БА ЧАНАРЫН СУДАЛГААНЫ ЯЛГАА

Abstract: Method whose final results are expressed in numbers is called quantitative. Quantitative methods include questionnaire, structured interview, sociometry and test, statistical analysis of documents, content analysis, and experiment. Qualitative methods include participant observation, unstructured interview, and focus group interview. I discuss methodology of using quantitative and qualitative methods, their specifics and advantages.

Key words: sociological research, qualitative and quantitative methods, methodology.

Эцсийн баримт өгөгдлүүд нь тоогоор илэрхийлэгддэг судалгааны аргыг тоон арга гэдэг. Тоон аргад анкет, стандарт сурвалжлага, социометр болон тест, статистик баримт бичиг судлах арга, контент-анализ, нийгмийн туршилт зэргийг багтааж болно. Тоон судалгааг голдуу социологийн таамаглал шалгах зорилгоор хийдэг тул, цуглуулах мэдээлийн агуулга хэлбэрийг урьдчилан тогтоож, хэлбэршүүлэлт хийсний үндсэн дээр тоон хэлбэрт шилжүүлэх нөхцөл бүрэлддэг.

Тэгвэл чанарын судалгааны үндсэн арга нь оролцсон ажиглалт, чөлөөт сурвалжлага, бүлгийн сурвалжлагын нэг төрөл болох фокус бүлгийн арга болно. Чанарын судалгааны гол хэрэглүүр нь судлаач бөгөөд өдрийн тэмдэглэл, захидал, сонин, сэтгүүл, ном, видео бичлэг, кино, фото зураг зэрэг мэдээллийн төрөл бүрийн туслах эх үүсгэвэрийг ашиглаж болно.

Чанарын судалгаа тооноос илүүтэйгээр үг өгүүлбэр, бичвэр мэдээлэлд, холбоо хамаарлаас илүү үйлдлийн субъектив учир холбогдолд, таамаглал шалгахад бус судалгааны эцэст таамаглал дэвшүүлэхэд, хэн юу гэж хариулсан, хэд нь тэгж хэлсэн гэдэгт бус яагаад ингэж хариулав гэдэгт гол анхаарлаа хандуулдаг.

Ян Дей “Чанарлаг өгөгдлийн шинжилгээ” номдоо энэ ялгааг дараах зургаар илэрхийлсэн юм.



Зураг1. Тоон ба чанарын судалгааны аргын хэрэглээ

Зургаас харахад тоон судалгаа тоо, категори, хийсвэрлэл, тайлбарлалд тулгуурладаг бол чанарын судалгаа учир утга, туршлага, сэтгэл хөдлөл, ойлгохуйд суурилдаг байна.

Чанарын арга хүмүүсийн тодорхой туршлага, сэтгэл догдлолыг ойлгож мэдэх зорилго бүхий эмпирик судалгаанд илүү тохиромжтой байдаг бол өгөгдлийг арай өндөр түвшинд нэгтгэхэд тоон стратеги чухал гэж үздэг тал бий. Гэхдээ өндөр төвшинд хийсвэрлэлээ ч утга учрыг хайхрахгүй байж болохгүй бас утгыг илрүүлэхдээ тоон үзүүлэлтийг харгалзах шаардлагатай.

Тоон ба чанарын судалгааны ялгааг дараах хэдэн зүйлээр тоймлон хэлж болох юм. /1.33-36/

Нэгдүгээрт. Танин мэдэхүйн зүй ёсны хэлбэршүүлээгүй аргууд тухайлбал чөлөөт сурвалжлага, ажиглалт, хувийн баримт бичиг судлах арга нөхцөл байдал, үйл явцыг амьдралын олон янзын төлөв байдалд нь цогц байдлаар шинжлэхийг эрмэлздэг. Түүнчлэн судалгааны үр дүнг тайлагнахдаа тодорхой хувь хүний үнэн бодитой үг яриаг өргөн ашиглана. Иймээс чанарын судалгаа амьдралын жирийн нөхцөл байдалд хүмүүстэй байнга холбоотой байж, тэдний харилцан үйлчлэлийг мэдэрч судалгаа хийхийг шаардана.

Тэгвэл тоон хандлага объектийн шинж төрхийн талаархи урьдчилсан таамаглалд тулгуурлан шинжилгээ хийх төлөвлөсөн схем загвар ашиглаж, сонгосон хувьсагчдын хоорондын холбоог олохыг эрмэлзэнэ. Харин сонгогдоогүй бусад хувьсагчдын олон янз байдал анхаарлын гадна үлддэг. Үүнээс үзэхэд урьдчилан тааварлахад бэрхтэй, шинэ үзэгдлийн хувьсал өөрчлөлт, үйл ажиллагааны нийтлэг бус хэлбэрийг судлахад чанарын хандлага үр нөлөөтэй.

Хоёрдугаарт. Чанарын судалгаа тусгай буюу нэгж, онцгой тохиолдлыг судлаж, түүнтэй төсөөтэй тохиолдлын явцуу хүрээнд үр дүнг дэлгэрүүлэн хэрэглэнэ. Үүнд нэг объектийн хувьд хийсэн дүгнэлт нөгөөд хийсэн судалгааны дүнтэй тохирохгүй байж болохыг анхаарах нь зүйтэй. Харин тоон судалгаа нэгтгэн дүгнэсэн шинж илүүтэй тул ижил төстэй олонлогт дүгнэлтийг хэрэглэх боломж ихтэйгээрээ ялгаатай.

Гуравдугаарт. Чанарын судалгааны дүнд тусгай онолын дүрстэйгээр хийгдэж буй аналитик нэгтгэн дүгнэлт нь тоон судалгаанд хэрэглэгддэг статистик дүгнэлтээс эрс ялгаатай. Тиймээс дүгнэлтээ батлах эсвэл няцаахдаа ижил объект дээр хийсэн /Ихэнхдээ огт өөр объект дээр хийсэн/ судалгааны дүнтэй харьцуулан үзнэ. Тэгвэл тоон судалгааны дүгнэлт эх нийлбэрийн статистик төлөөлөлд тулгуурлана. Дүгнэлт үнэн зөв болох нь бусад объектод энэ холбоо дахин давтагдах байдлаар илэрнэ.

Дөрөвдүгээрт. Чанарын судалгааны судлаач судалгааны бүх үе шатанд оролцох тул түүний хувийн үнэлэлт дүгнэлт, үнэлэмжийн тогтолцооноос олон зүйл хамаарна. Иймээс субъективизм тухайн судалгаанд илэрч болохыг үгүйсгэх аргагүй. Бас тоон судалгааг объектив хэмээн нотлохыг оролдогч судлаачдын дотор нэг ижил өгөгдөлд тулгуурлан огт өөр дүгнэлт хийх явдал байдгийг мартаж болохгүй.

Тавдугаарт. Тоон хандлага статистик аргыг гол болгодог бол чанарын стратеги мэдээллийн олон эх үүсвэрт тулгуурлан объектийг тал талаас нь шинжлэхийг чухалчлана.

Социологийн ТООН БА ЧАНАРЫН аргазүйн СТРАТЕГИЙН ЯЛГАА

Тоон арга зүй	Чанарын арга зүй
---------------	------------------

Онол-арга зүйн үндэс

- | | |
|--|--|
| <ul style="list-style-type: none"> • Реализм • Үнэн, объектив мэдлэг • Параметрийн хоорондох холбоо хамаарлын тодорхойлох | <ul style="list-style-type: none"> - Феноменологи - Релятивизм - Үзэгдэл үйл явцын ерөнхий дүр зургийг тоочин бичих |
|--|--|

Шинжилгээний чиглэл

- | | |
|---|---|
| <ul style="list-style-type: none"> - Ерөнхий, бүхэл - Үзэгдэл тохиолдлыг адилтгах замаар ангилах хийх | <ul style="list-style-type: none"> - Онцгой, хэсэг - Үзэгдэл тохиолдлыг тодорхойлон бичих |
|---|---|

- | | |
|--|---|
| <ul style="list-style-type: none"> - Анхаарлын төвд бүтэц; - Гадаад: объектив зүйл | <ul style="list-style-type: none"> - Анхаарлын төвд хүн; Дотоод: субъектив зүйл |
|--|---|

Судалгааны зорилго, зорилт

- | | |
|---|---|
| <ul style="list-style-type: none"> Шалтгаацлын тайлбар өгөх Холбоо хамаарлыг олох | <ul style="list-style-type: none"> Учир утгыг тайлбарлах, ажигласнаа ойлгох Үзэл баримтлалд хүрэх |
|---|---|

Шинжилгээний нэгж

Баримт, үзэгдэл

Субъектив утга, мэдрэмж

Найдвартай байдал

Тогтоосон холбоо лавтай давтагдах

Мэдээлэл бодитой байх

Шинжилгээний логикДедуктив: Ойлголтыг задлах
зэргээр хийсвэрлэлээс
баримтад хүрэхИндуктив: Амьдралын
тухай яриа зэрэг
баримтаас үзэл
баримтлалд хүрэх**Арга маяг**Хатуу, хүйтэн
СистемчлэхУян, дулаан
Дүрслэн бодохуй, төсөөлөл

Чанарлаг аргын онолын үндэс нь Э. Гуссерлийн феноменологи, А. Шютцийн “өдөр тутмын социологи”, Г. Гарфинкелийн угсаатны аргазүй, Дж. Мид, Ч. Куль, Томас нарын бэлгэ тэмдгийн интеракционизм, Бергер, Лукманы “Бодит байдлын нийгмийн бүтээц”, А. Страусс, Дж Корбины “үндэслэгдсэн онол” зэрэг болно.³

Тэд нийгмийн бодит байдал нь нийгмийн гишүүдээс үл хамаарах объектив бодитой зүйл бус, харин хүний ухамсрын бүтээгдэхүүн болох тул үйлдэгчийн ухамсрын байдлаас хамааран өөрчлөгдөж байдаг гэж үзсэн. Энэхүү баримтлалдаа тулгуурлан позитивистуудын судалгааны горим нь шинэ бодит байдлыг бий болгож, судлах объектоо өөрчилдгийг тэд ойлгодоггүй гэж шүүмжилжээ.

Социологич болон судлагдагчдын харилцан үйлчлэлийн нөлөөгөөр тэдний үзэл бодол, санаа өөрчлөгдөж, бодит байдлын ертөнц хувирах явдал гардаг байна. Иймээс социологичийн хувийн амьдралын туршлага, мэдлэгт тулгуурлан зохиосон анкетаар авсан мэдээлэл нь жинхэнэ бодит байдлыг тусгаж чадахгүй, харин хариулагчийн намтар түүхэнд түшиглэвэл үнэнийг мэдэж болно гэж үздэг. Сонгодог социологи судалгаа явуулахдаа судалгааны онол, таамаглал, үндсэн ойлголтын тайлбарлал, ойлголтын задалгаа зэргээс анкетын логик схемд шилждэг. Ийнхүү дедуктив аргад тулгуурлан гаргасан таамаглалаа статистик төлөөллийг гол болгосон өргөн судалгаа хийж шалгадаг. Гэтэл судалгааны практикт онолын үндэслэл бүхий зөв таамаглал дэвшүүлэх нь зөвхөн бэлтгэлийн үе шатанд тэр бүр хэрэгжих бололцоогүй, заримдаа судалгааны эцэст таамаглал төлөвших тохиолдол ч цөөнгүй гарч байна.

Ялангуяа Монголын нийгэм зах зээлийн тогтолцоонд шилжих үйл явц үргэлжлэн хуучин тогтолцооны үед бүрэлдсэн нийгмийн сэтгэл зүй, үнэт зүйлс, тогтсон хандлага өөрчлөгдөн, шинэ үнэт зүйлс хараахан төлөвшөөгүй, нийгмийн сэтгэл зүй тогтворгүй байгаа өнөө үед олон нийтийн санал асуулгаар нийгэмд тулгарч буй нарийн төвөгтэй асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлох бүр ч боломжгүй юм.

Ийнхүү сонгодог социологи таамаглал шалгахад гол анхаарлаа хандуулдаг тул мэдээлэл цуглуулахдаа илүү хэлбэршүүлсэн тухайлбал анкет, стандарт сурвалжлага зэргийг өргөн хэрэглэдэг. Манай оронд хийгдэж буй судалгаа ч үндсэн мэдээлэл цуглуулахдаа дээрх аргыг голлон хэрэглэж ирсэн юм.

Харин шинжлэх ухааны мэдлэгийг хэлбэршүүлэх сонгодог арга барилаас аль болохоор татгалзаж социологичийн гүйцэтгэх үйл ажиллагаа нь аливаа мэдлэг хөгжих түүхэн үйл явцын логиктой илүү ойр байх хэрэгтэй гэсэн ойлгохуйн социологийн онол арга зүйд тулгуурласан аргуудыг чанарын шинжилгээ хэмээн нэрлэсэн байна. Энэ арга зүй тулж ажиглахаас хийсвэр сэтгэхүйд шилжих, ингэхдээ социологич хийж буй дүгнэлт алхам бүрээ хянаж, үүнээс өөр ямар боломж байж болохыг нягтлан үзэх зэргээр эвристик аргад тулгуурлан зөв дүгнэлт хийх, эцэст нь гаргасан дүгнэлтээ ямар онолоор тайлбарлах боломжтойг тогтоох, эсвэл шинэ онолд хүрэх шаардлагатай хэмээн үздэг байна.

Чанарын судалгааны стратеги.

Чанарын шинжилгээний хэд хэдэн хэв маяг байдаг гэж зарим эрдэмтэд үздэг. Үүнд: давтан хийх судалгаа, нийгмийн дээд болон доод хэсгийн судалгаа, тайлбарлалын стратеги, егөөдлийн стратеги гэх мэтээр ангилан авч үздэг. /2/

Давтан хийх судалгаа гэдэг нь социологич нэг объект юм уу хариулагчтай олон дахин уулзаж, нийгмийн бодит байдал түүнд гарч буй өөрчлөлтийг ойлгохыг хичээнэ. Энэ нь олон

нийтийн санал бодлын давтан хийх судалгаа бус харин алив үзэгдэл, тохиолдол, хувь хүн болон бүлэг хүмүүс, нийтлэгийг олон дахин ажигласны үр дүн болно. Ийм судалгаа хийх санааг Чикагогийн сургуультай нар гаргаж нийгмийн статусын өөрчлөлтийг судлахдаа хэрэглэсэн гэдэг. Өнөөгийн Монголын нийгэм, эдийн засагт гүнзгий өөрчлөлт гарч, хүн нийгэмд өөрийн эзэлж буй байр сууриа олох, нийгмийн ижилслээ эрэлхийлж, угсаатны бүлэг, эд хөрөнгийн байдлаар ялгарах тодорхой бүлэг хүмүүстэй өөрийгөө жишин үзэж байна. Иймд энэ үзэгдлийг гүнзгий ойлгоход тухайн объектод ажиглалт, сурвалжлагын аргыг давтан хийх явдал их ач холбогдолтой.

Та ямар хүмүүстэй өөрийн сонирхол, үзэл бодлоо хуваалцахыг илүүтэй эрмэлздэг вэ, Таны бодлоор ямар бүлэг хүмүүст танд тохиолдож буй бэрхшээл, зовлон давтагдаж байна вэ гэх мэт асуултыг тавьж, сурвалжлагч гарч буй олон янзын агуулга бүхий хариултыг тэмдэглэж авна. Тодорхой хугацааны дараа респонденттой дахин уулзаж, нийгмийн ижилсэлд гарч буй өөрчлөлтийн хандлагыг тогтооно.

Чанарын судалгааны стратегийн өөр нэг хэв маяг нь нийгмийн “элит” хийгээд “доод” хэсгийн судалгаа юм. Үүнд нэг талаас гэр оронгүй, тэнэмэл хүмүүс, архаг архичид, мансуурагчид, биеэ үнэлэгчид нөгөө талаас шилдэг бизнесмэн, эрдэмтэд, зохиолчид, дээд тушаалын удирдах ажилтан, их хурлын эрхэм гишүүдээс цөөн хүнийг төлөөлүүлэн судлаж болох юм. Энэ хандлага нийгмийн харилцааны эсрэг тэсрэг огт өөр талуудыг гүнзгий таних, “эгэл” хүмүүсийн жирийн амьдралыг нарийн ойлгоход тус болно. Оросын ШУА-ийн социологийн институт нийгмийн доод хэсгийн дунд судалгаа явуулсан нь нийгэмд илэрч буй гажуудалтай холбогдсон асуудлыг шийдвэрлэх арга замыг илрүүлэх, нийгмийн ёс суртахуун ухамсарт гарч буй өөрчлөлтийг танин мэдэхэд чиглэгджээ. Тухайлбал 1970-аад онд биеэ үнэлэх явдлыг нийгмийн шаар шавхруу, үл бүтэх хүмүүсийн ажиллагаа хэмээн олон түмэн үзэж байсан бол 1990-ээд онд энэ үзэгдэл нь зах зээлийн харилцааны нөхцөлд байх ёстой зүйл мэтээр үзэх хандлага буй болсон байлаа.

ТАЙЛБАРЛАЛЫН СТРАТЕГИ гэдэг нь нэг үзэгдлийг олон талаас нь янз бүрийн үзэл хандлагаар судална гэсэн үг юм. Энэ хандлага асуудлын мөн чанарыг гүнзгий ойлгоход тус болох бөгөөд өнгөц харахад илэрхий үнэн мэт зүйл бүхэн огт өөр утга агуулгатай байх нь нэн элбэг тохиолддог.

Ардчилал, ил тод байдал, бүс нутгийн аж ахуйн биеэ даасан байдал нь үндэстэн хоорондын ширүүн мөргөлдөөн буй болгосон нь ямар учиртай вэ? Энэ талаар үзэгдлийн учир шалтгааныг бүрэн илрүүлээгүй ч гэсэн тус бүрдээ үнэний хувь бүхий олон тайлбарлал, үндэслэл гаргаж болно. Тухайлбал:

А/ Бидний ядуу зүдүү амьдралаас болж угсаатан, үндэстний гэгдэж буй нөөц баялгаа булаацалдан, улмаар энэ нь үндэстний мөргөлдөөнд хүргэж байна.

Б/ Улс орны ард түмнүүдийн өнгөрсөн түүхийн бодит үнэн үндэстэн хоорондын хурцадмал байдлыг бий болгов. Учир нь урьд өмнө нууц далд байсан олон баримт тухайлбал, Балти орчмын улсуудыг нэгтгэх тухай Молотов, Риббентроп нарын нууц гэрээ зэрэг нь нэгэнт олон нийтэд илэрхий болсон.

В/ Төрийн удирдлагын тогтолцоон дахь том жижиг ард түмний тэгш бус байдал нь бага улсуудын эрх ашгийг хохироож байсан гэсэн хардлага, сэрдлэгийг төрүүлэх болов. Түүнээс гадна зөвхөн сэтгэл зүйн талын маш хялбар тайлбар өгч бас болно.

Г/ Дэлхий ертөнц тогтворгүй болж, холбоо харилцаа суларч, эдийн засаг, байгал орчин “сүйрч” нийгмийн мөргөлдөөн гэмт хэрэг өсч, хүн өөрөө хамгаалалтгүй болсноо мэдэрч байгаагаас, түүх гарвал зүйн талаас хамгийн ойр, нэг хэлтэй, түүхийн ерөнхий нэг хувь заяа, соёл бүхий нийгмийн тэр нийтлэгт юуны түрүүнд хандаж, хамгаалах, дэмжих ёстой өөрийн угсаа-үндэстний нийтлэгтэй ойртон ижилсэхийг эрмэлздэг байна.

Дээрх тайлбарлал бүгд үнэний хувьтай боловч аль нь ч төгс сайн бүрэн хариулт болж чадахгүй байж болох юм. Энэ тайлбарлалын стратегийн дагуу хийх чанарын шинжилгээний нэг жишээ юм.

1988 онд Оросын ШУА-ийн социологийн хүрээлэн 27 хүнээс зорилгот түүврийн аргаар сурвалжлага авч Сталиныг шүүхэд шилжүүлэх тухай тэр үеийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуугиж байсан саналыг хүмүүс хэр дэмжиж байгааг мэдэх зорилго тавьжээ. Сурвалжлагыг ажилчин, лам, тэрс үзэлтэн, хамтралчид, инженер зэрэг янз бүрийн хүмүүсийг хамруулан хийжээ.

Сталиныг шүүхэд шилжүүлэх хэрэгтэй юу гэсэн эхний асуултад 85% нь зүйтэй гэж хариулжээ. Сталинг шүүхэд шилжүүлэх үед болон түүний дараа ямар үр дагавар гарч болох вэ

гэсэн асуулгад хариулснаас үзэхэд, үүнээс болж нийгэмд аюултай үзэгдэл мөргөлдөөн гарч болох юм гэсэнтэй ихэнх нь санал нэгтэй байв. Эндээс тоон болон чанарлаг аргын алийг хэрэглэв гэдгээс хамааран огт өөр үр дүнд хүрч болохыг энэ судалгаа харуулав.

Ямар нэг үзэгдэл баримт янз бүрийн нөхцөл байдалд харилцан адилгүй үндэслэгээтэй байдгийг харгалзан үзнэ. Иймээс аливаа үйл явдлыг тайлбарлахдаа тэр үеийн нөхцөл байдалтай нь нягт холбохыг эрмэлздэг чанарын судалгааны бас нэг стратеги байдаг. Хамтралчид нь хурал эхлэхийн өмнө явган сандал дээр сууж хамтралын дарга болон аж ахуйн дэг журмыг аль муу үгээр хэлж байснаа хурал дээр огт өөр байдалтай болдог байна. Энэ онцлог байдлыг үйлдвэрлэлийн харилцааг судласан А. П. Алексеев бас ажигласан байна. Иймд ажиглалт, сурвалжлага, бүлгийн маргаан зэрэг нь үнэнийг зөвөөр ойлгоход тустай.

Түүнээс гадна хамт олныг судлахдаа судалгааны үр дүн, тэдэнд тохиолдож буй бэрхшээлтэй холбогдсон асуудлыг судалгаа явуулсан хамт олны дунд хэлэлцүүлж, маргаан ярилцлага зохиодог байна. Хүмүүсийн тайлбар, татгалзал, нотолгоо нь гаргасан дүгнэлтийг гүнзгийрүүлэхэд чухал түлхэц болдог.

Ю. Выглайдын удирдлагын дор Эстоны социологичид хөдөө аж ахуйн сэдвээр судалгаа явуулаад судалгаагаар илэрсэн үндсэн **нөхцөл байдал, зөрчилдөөнийг харуулсан жүжиг тоглож**, тухайн **аж ахуйн хамт олонд үзүүлээд**, энэ сэдвээр “жүжигчид” болон ажилчдын хооронд маргаан зохиож, тухайн асуудлыг шийдвэрлэх шинэ арга замыг илрүүлсэн байна.

Тоон болон чанарын судалгааны аргын алийг сонгох нь олон хүчин зүйлээс шалтгаална. Үүнд ЮУНЫ УРЬД СУДАЛЖ БУЙ АСУУДЛЫН ШИНЖИЙГ ХАРГАЛЗАНА. Хэрэв хижээл настуудын өвчлөлтийг судлая гэвэл анкетын арга, өвчтөний түүх, гажуудалт зан төлөвийг судлахад оролцон ажиглах арга илүү үр дүнтэй байж болох юм.

Бас судлаачид онолын ямар үзэл баримтлал, хэрэглэж буй нь аргын сонголтод нөлөөлнө. Бэлгэ тэмдгийн интеракционизмийг баримтладаг судлаач стандарт хувьсагч бүхий шууд ажиглалтыг чухалчилна.

Судалгаа явуулах хугацаа хөрөнгө хүчний бололцоог бас харгалзаж үзнэ. Тухайлбал шуудангийн асуулга ганцаарчилсан сурвалжлагаас, мэдээллийн хоёрдогч шинжилгээ анхдагч мэдээлэл цуглуулахаас хямд хялбар байна.

Түүнчлэн захиалагч, санхүүжүүлэгч, судлагдагсад ойлгомжтой байхуйцаар судалгааны төрөл хэлбэрийг сонгох шаардлага гарч болохыг үгүйсгэх аргагүй. Тухайлбал санхүүжүүлэгч байгууллага чанарын бус тоон үзүүлэлтийг илүү эрхэмлэж болох жишээтэй.

Ер нь чанарын ба тоон судалгааны аль нэгийг онцлон үзэх, эсвэл тэдгээрийг эсрэгцүүлэн тавих нь утгагүй гэж олон судлаач үздэг. Иймээс тэдгээрийг хослуулан хэрэглэх /триангуляци / шаардлагатай болж байна.

Ном зүй

1. В.В.Семенова. Качественные методы: Введение в гуманистическую социологию. М., 1998.
2. В.А.Ядов. Стратегия и методы качественного анализа. // Социология 4М.М., 2003.